



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/35

Ханх сум

Эрүүл мэндийн төвийн чанар
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй
байдлын багийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 166/А/565 тоот тушаал, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/112 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн, үйлчилгээний чанарыг сайжруулах, дотоод үйл ажиллагааг, хяналтыг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Анхтуяа (Эрүүл мэндийн төвийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

Б.Бямбажаргал (Нягтлан бодогч)

Б.Энхдорж (Бүртгэл мэдээллийн ажилтан)

Т.Сэргэлэн (Ахлах сувилагч)

Ажлын хэсгийн нарийн бичиг:

Б. Гантуяа (Сувилагч)

2. Тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын багийн гишүүдийн чиг үүргийг хавсралтаар баталсугай.

3. Чанарын албаны дүрмийг үйл ажиллагаа, тусламж үйлчилгээндээ мөрдөж ажиллахыг чанарын албаны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Баттүвшин)-д даалгасугай.

ДАРГА

Л.ДАВААБАЯР



Сумын Засаг даргын 2024 оны
06 дугаар сарын 23-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт



ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАГИЙН
ГИШҮҮДИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ

1.ЭМТҮЧАБ-ын дарга Д.Анхтуяа - ЭМТ-ийн эмнэл зүйн үйл ажиллагаатай холбоотой талуудын уялдаа холбоог ханган, хамтран ажиллах

2.Санхүүгийн хэсэг Нягтлан бодогч Б.Бямбажаргал – ЭМТҮЧАБ-ыг сайжруулах, урамшуулах үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэн, зарцуулах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах ажиллах

3.Бүртгэл мэдээллийн ажилтан Б.Энхдорж - ЭМТҮЧАБ-ын үйл ажиллагаанд шаардлагатай, тоо мэдээлэл цуглуулан, дүн шинжилгээ хийхэд мэдээллээр ханган ажиллах

4.Ахлах сувилагч Т.Сэргэлэн - ЭМТҮЧАБ-ын сувилахуйн бодлогыг хэрэгжүүлэх, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах

5.Сувилагч Б.Гантуяа - ЭМТҮЧАБ-ын эмнэлзүйн эрсдэл гаргахаас сэргийлэх, тохиолдлыг бүртгэх, шалтгааныг тодруулах, эргэн мэдээлэх суралцах үйл ажиллагааг чиглүүлэн ажиллах